



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар A/378

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолын 10.1, 10.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Шинэ коронавируст халдварт (Ковид-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай” А33, “Уламжлалт анааах ухааны өвчний бүлэг, оношийн ангилал, код шинэчлэн батлах тухай” А/55 дугаар тушаалын хэрэгжилтийг тус тус хангах зорилгоор Эрүүл мэндийн яам, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, аймгуудын Уламжлалт анааах ухааны эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүд хамтран “Эмийн ургамлын тархалт, нөөц ашиглалт, хамгаалалт” сэдэвт уулзалт зохион байгуулахад Уламжлалт анааах ухааны эмнэлэгт 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн тухайн төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлаас олгохыг Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус дааг гасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

• 231010851